

ДИЖИТАЛ СУРАЛЦАХУЙ БА ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ

Дижитал өөрчлөлт нь боловсрол олгох, удирдах, сурган хүмүүжүүлэх ажлыг зохион байгуулахад нэгдсэн, шинэлэг хандлагыг хэлнэ. Уг ажлыг бүхэлд нь цогцоор нь шийдэхийн тулд хүний нөөцөө чадавхжуулах, дижитал сургалтыг дэмжих технологийн шийдэл, онлайн сургалтын хөтөлбөрт нийцүүлсэн сургалт, багш, суралцагчдын дижитал чадамжийг дээшлүүлэх, хүртээмжтэй, нээлттэй сургуулийн системийг төлөвлөж, байгуулах, цаашлаад багш, суралцагчийн сайн сайхан байдал, хувийн нууц, аюулгүй байдалд дижитал өөрчлөлтөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг мөн сайтар судлах шаардлагатай.

COVID-19 нь улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний дотор боловсролыг хувирган өөрчлөх хэрэгцээг нийгэмд хурцаар мэдрүүлсэн. Манай улс ч цар тахлын эсрэг үргэлжилсэн хариу арга хэмжээ болон ирээдүйд тохиолдох эрсдэлт, гамшгийн нөхцөлд бэлэн байхын тулд чанартай дижитал болон холимог сургалтын хүртээмжийг бэхжүүлэх, өргөжүүлэх ажлыг эрчимжүүлсэн.

Боловсролын дижитал өөрчлөлт нь сургалтын хоцрогдлыг арилгах шийдвэрлэх, боловсролын тогтолцоог илүү хүчтэй болгох шийдэл гэж судлаачид үзэж байна. Ялангуяа хүртээмж, чанарыг сайжруулахын тулд технологид суурилсан шийдлээс гадна сургалтын ач холбогдол, үр ашгийг дээшлүүлэх, түүнчлэн суралцагч болон тогтолцооны түвшин дэх саад бэрхшээлийг даван туулах чадварыг бэхжүүлэхтэй холбоотой юм.

Дижитал технологийн хүртээмжтэй, тэгш, тогтвортой хандлага, түүнчлэн цахим сургалтын аюулгүй, үр дүнтэй хэрэглээ нь боловсрол ирээдүйн гол стратеги юм.

Боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлж, боловсролын салбарын цахим шилжилтийг дэмжсэн олон томоохон ахиц дэвшил байгааг тоймлон танилцуулахад:

- Боловсролын салбарын бүх түвшинд боловсролын удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлж, боловсролын үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулж байна.
- Багш, суралцагчид зориулсан орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлсэн үндэсний цахим сургалтын MEDLE.MN платформыг хөгжүүлж, хэрэглэж эхэлсэн. Уг ажлыг цогцоор нь шийдэхийн тулд холбогдох боловсон хүчнээ чадавхжуулж байна.
- Төрийн өмчийн зургаан их сургуулийн суралцагчид харьяалал харгалзахгүйгээр хичээл сонгох, боловсролын зарим үйлчилгээ авах боломжтой болсон.
- Боловсролын нэгдсэн сүлжээг үүсгэж, салбарын мэдээллийн урсгал, контентын хэрэглээний ачааллыг даан ажиллах чадамжтай мэдээллийн технологийн дэд бүтэц бүрдээд байна. Төрийн болон орон нутгийн өмчийн бүх ЕБС-ийн хичээлийн байрыг боловсролын нэгдсэн сүлжээнд холбосон. Энэхүү сүлжээний нийт хурд нь 4.75 Gbps байна.
- Боловсролын салбарын мэдээллийн систем, сургалтын цахим контент, удирдлагын систем, мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ болон боловсролын дата төвийн хяналт, тогтвортой ажиллагааг хангах, хөгжлийн асуудлыг төр цогцоор нь авч хэрэгжүүлж байна.
- COVID-19 цар тахлын үед илэрсэн цахим хуваагдал нь сурлагын хоцрогдол үүсэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн ч багш нарын мэдээллийн технологийн ур чадвар нэмэгдсэн байна. Мөн багшийн МХХТ-ийн цогц чадамжийн нийтлэг шаардлага

(БШУ-ны Сайдын А/67, 2020.02.05)-ыг баталсан бөгөөд цаашид энэхүү шаардлагын хүрээнд багшийг чадавхжуулах шаардлагатай байна. [5]

- Цахим, танхим, холимог сургалтын хэлбэр, 5/9 зарчимд тулгуурласан менежментийг хэрэгжүүлсэн.
- COVID-19 цар тахлын улмаас багш нар зайнаас ажиллах арга зүйд богино хугацаанд суралцан, өөрсдийн боломж, мэдлэгт тулгуурлан зайн сургалтыг зохион байгуулах МХХТ-ийн бэлэн байдлын туршлага хуримтлуулж хатуу хөл хорионы үеийг даван туулсан.
- Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд боловсролын цахим шилжилттэй холбоотой асуудлуудыг тусгасан. Боловсролын салбарын зангидсан нэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулж батлах хэрэгцээ байгааг “Боловсролын салбар дахь мэдээлэл харилцаа холбооны технологийн тойм шинжилгээ”-д дурдсан байна.
- 2022 оноос БШУЯ дээр Цахим бодлого, статистикийн хэлтэс, БЕГ дээр Цахим шилжилт, нэгдсэн статистикийн газар, БШУЯ-ны дэргэд Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ байгуулагдаж, цахим шилжилтийн хувьд бодлого, хэрэгжилт, технологи хөгжүүлэлтийн үндсэн бүтэц бий болсон. Мөн бүх аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт мэдээллийн технологи, сүлжээ, систем хариуцсан мэргэжилтний орон тоог шинээр бий болгосон.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

Цар тахлын үе дэх дижитал хуваагдал нь олон суралцагчдыг зайн сургалтын боломжоос гадуур үлдээх, урьд өмнө нь байсан сурлагын хоцрогдлыг улам хурцатгаж байгааг тодруулав.

Сургалтын дижитал өөрчлөлтийг бий болгоход анхаарах гол асуудлууд нь:

- **Дижитал хуваагдал** нь ихэвчлэн орлогын хэмжээ, газар зүйн байршил, ур чадвар, хүйс, тусгай хэрэгцээт, хэл, соёлын ялгаатай хүмүүст илүү хүндээр тусдаг. COVID-19 цар тахлын үед 330 сумын сургуулийн 172,300 сурагч, 46 багийн сургуулийн 6,277 сурагч, нийт 178,577 сурагч дэд бүтэцгүй, алслагдсан, интернэтгүй, цахилгаангүй, техник хэрэгсэлгүй гэх мэт шалтгаанаар цахим сургалтад хамрагдах боломжгүй байв [2].

ЕБС-ийн нийт суралцагдын 4-6% (орон нутгийн онцлогоос хамааран харилцан адилгүй) нь огт теле хичээл үзэх боломжгүй буюу мэдээлэл технологийн хэрэгсэл ашиглах боломжгүй (огт байхгүй эсвэл ажиллахгүй) хүүхдүүд байв. Үүнд ихэвчлэн аймаг, сумын төвөөс алслагдмал амьдардаг малчдын хүүхдүүд, өвөлжилт, хаваржилт хүндэрснээс хичээл үзэх завгүй, оторт гарсан, салхи, шуурганаас үүдэн сүлжээ тасарсан, суурин газруудад интернэт, кабелийн төлбөрөө төлөх боломжгүй эсвэл огт мэдээлэл технологийн хэрэгсэлгүй, орлогын түвшин доогуур өрхийн болон үндэсний цөөнхийн хүүхдүүд багтаж байна. Улсын дунджаар теле хичээлийн үзэлтийн ирц 81% байв. []

Хэдийгээр теле хичээлийг анги, хичээл тус бүрээр бэлтгэн нэвтрүүлж байсан ч гэр бүлийн орчин нөхцөл, дэд бүтцийн хангамж, алслагдсан байдал, 2 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийн хүүхдүүдэд теле хичээлийн цагийн давхцал, тусгай хэрэгцээт хүүхдийн онцлог хэрэгцээнээс хамааран хичээлийг бүрэн үзэж чадахгүй байх зэрэг бэрхшээл учирч байсан. []

- **Боловсролын салбарын МХХТ-ийн дэд бүтэц** дутмаг байна. Төрийн болон орон нутгийн өмчийн бүх ЕБС-иудыг холбосон боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болсон хэдий ч хичээлийн болон дотуур байр, цэцэрлэгүүд бүрэн интернэтэд холбогдоогүй байна. Мөн томоохон бэрхшээл бол дотоод сүлжээний орчин бүрдээгүй, ЕБС-д сүлжээ хариуцсан мэргэжилтэн ажиллах орон тоо байхгүй, цалин бага учраас сургуульд мэргэжлийн хүн ажиллахгүй байгаа зэрэг хүний нөөцтэй холбоотой сорилтууд үүсэж байна [5].
- **Суралцагчдын МХХТ-ийн чадвар**, бие даан суралцах чадвар зэрэг зайнаас суралцахад шаардагдах ур чадвар хангалтгүй байна. Цахим сургалтад хамрагдах боломжтой байсан ч суралцагчдад хэрхэн боловсролын үйлчилгээ авч, үр ашгийг хүртэх тал дээр ур чадварын ялгаа байсаар байна []
- **Багш нарын МХХТ-ийн чадвар** сул байна. Судалгааны үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан нийт багшийн 73.3% нь өмнө нь зайн сургалтаар хичээл зааж байгаагүй, 20% нь цахим хэрэгсэл ашиглаж мэдэхгүй гэж хариулсан байна [17].
- **Боловсролын нээлттэй нөөц материал** (цахим сурах бичиг, теле хичээл, аудио, цахим хичээл, контент, интерактив, бие даан суралцах дасгал ажлын дэвтэр гэх мэт) бий болсон ч үүнийг ашиглах хэрэглэгчийн хандалт учир дутагдалтай, боловсролын бүх түвшний суралцагчдад зориулсан нэгдсэн нэг сан үүсээгүй байна.
- **Өгөгдөл, мэдээллийн найдвартай байдал, ашиглалт сул.** Боловсролын технологийн хөгжилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бодит цаг хугацааны анхдагч өгөгдөл, мэдээлэл нь тодорхой бус, бүрэн бус байгаагаас гадна найдвартай эх сурвалж дутмаг.
- **Цахим сургалтад шилжсэнээр кибер дээрэлхэлт, онлайн хүчирхийлэл, цахим донтолтод өртөх, хувийн мэдээллээ алдах** эрсдлийг нэмэгдүүлж байна.

ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Суралцахуйг сэргээх – Дижитал суралцахуй болон хувирган өөрчлөлт

Цар тахлын дараа бүх сургуулиудыг аюулгүй, бүрэн нээлттэй байлгах, сурлагын хоцрогдлыг арилгахад XXI зууны иргэнд байх үндсэн ур чадварт (тоо бодох, унших, дижитал чадвар гэх мэт) сургах, илүү сайн бодлогыг хэрэгжүүлэх, дижитал технологийг ашиглах, илүү тэгш байдлыг хангах хэрэгцээ шаардлага үүсч байна.

Дижитал суралцахуй нь дараах зүйлд нийцсэн байна. Үүнд:

- **Хүртээмжтэй, уян хатан байдлыг хангах дэд бүтэц, сүлжээ, төхөөрөмжүүд:** Үүнд дижитал хэрэгслээр дамжуулан тэгш боломж, хүртээмжийг хүртэж чадахгүй байгаа суралцагчдад зориулсан технологийн шийдэл багатай, бүр цаашлаад технологигүй шийдлүүдийн багц багтаж байгаа юм.
- **Дасан зохицсон сургалтын агуулга, нөөц** нь эмзэг бүлгийн суралцагчдад тохирсон байх. Сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, нээлттэй цахим болон зайн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулах.
- **Багш нарыг чадавхжуулах, сургалтад хамруулах**, тэдний МХХТ-ийн чадвар, заах арга зүйн чиглэлээр зайн болон дижитал сургалтад шилжихэд дэмжлэг үзүүлэх.

- **МХХТ-ийн суурь чадварын талаарх сургалт, боловсрол** нь цахим орчны ёс зүйтэй, зөв зохистой хэрэглээ, олон нийтийн мэдээлэл, кибер аюулгүй мэдээллийг олж авах мэдлэг зэргийг хамаарна.

Боловсролыг хувирган өөрчлөхөд - Дижитал суралцахуй болон хувирган өөрчлөлт

Дижитал өөрчлөлтийг идэвхжүүлэхийн тулд боловсролын тогтолцоо нь дараах чиглэлд нийцсэн байна. Үүнд:

- Цахим сургалтын тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- Насан туршдаа суралцах, боловсрох хэрэгцээг нээлттэй, цахим, зайн сургалтаар хангах боломжийг бүрдүүлэх.
- Насан туршийн боловсролын үр дүнг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх механизмыг бий болгох.
- Боловсролын нээлттэй нөөц материалын хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Боловсролын, сургалтын үйл ажиллагаанд технологи, интерактив, мультимедиа хэрэгслийн ашиглах.
- Бүх шатны боловсролын байгууллагын багш, сурган хүмүүжүүлэгч, удирдах ажилтнуудын дижитал чадварыг системтэйгээр дээшлүүлэх.
- Багш, суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг цахимаар үнэлэх технологи бүрдүүлэх.
- Бүх түвшний боловсролын салбарын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлснээр салбарын бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хэрэглэж хэвших, өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, цахим орчинд аюулгүй байдлаа бүрдүүлэхэд төрийн, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, түншлэл, оролцоог хангах;

Эх сурвалж:

- [1] БШУЯ, МУИС, UNICEF. (2020). *Хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн асуудал, эрсдэлийг илрүүлэх судалгааны тайлан*. Улаанбаатар
- [2] БШУЯ, Боловсролын хүрээлэн. (2021). *Сургууль завсардаж болзошгүй хүүхдийг илрүүлэх судалгааны тайлан*. Улаанбаатар
- [3] UNICEF. (2020). *Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтад цахим платформ ашиглах боломж, нөхцөл байдлын судалгаа*. Улаанбаатар
- [4] БШУЯ, UNICEF, IRIM. (2020). *Онцгой байдлын үеийн теле хичээл, түүний үр дүн тохиромжтой байдал*. Улаанбаатар
- [5] БШУЯ, UNESCO. (2022). *Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн зорилго-4”-ийн хэрэгжилтийн ахиц дэвшлийн тойм үнэлгээ (2016-2021)*. Улаанбаатар
- [6] UNESCO. (2020). *Залуучууд, насанд хүрэгчдийн суралцахуйг дэмжих нээлттэй, зайны сургалт*. КОВИД-19-ийн эсрэг ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын хариу арга хэмжээ Боловсролын онцлох асуудлууд Асуудал № 2.5 –2020/06
- [7] UNESCO. (2021). *Монгол улсын боловсролын салбар дахь Мэдээлэл харилцаа холбооны технологийн бодлогын тойм шинжилгээ*
- [8] UNESCO. (2019). *Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ*
- [9] МУИХ (2020). *“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*

- [10] МУИХ (2020). *Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр*
- [11] БСШУСЯ. (2017). “Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь” төслийн эцсийн үнэлгээний тайлан
- [12] БСШУСЯ, БҮТ. (2021). *Сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх судалгааны эцсийн тайлан*
- [13] БШУЯ. (2020). *Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030*
- [14] БШУЯ. (2021). *Дээд боловсролын сургалтын байгууллагын цахим сургалтын орчин, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийн тайлан*
- [15] ЦХХХЯ (20..). *Цахим үндэстэн дунд хугацааны зорилтот хөтөлбөр, 2022-2027*
- [16] БШУЯ. (2021). *Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл, Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах цогц төлөвлөгөө /2021-2023/*
- [17] БШУЯ. (2021). *Ковид19-ийн боловсролын салбарт үзүүлж буй үр нөлөөг бууруулахад чиглэсэн бодлого, тайлан мэдээлэл*
- [18] Transforming Education Summit (2022). *Futures of Education Briefing Notes*
- [19] OECD. (2021). *21st-Century readers developing Literacy Skills in a Digital World*
- [20] UNESCO (2021). *Reimagining our futures together a new social contract for education*